# МОНГОЛ - ЯПОН УЛСЫН ХООРОНДОХ ЭДИЙН ЗАСГИЙН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ЗАРИМ АСУУДАЛД

**Д.Батмөнх, О.Энхболд**

Стратегийн судалгааны хүрээлэнгийн эдийн засгийн судалгааны секторын ЭША

**Abstract:** Half a year before Mongolia signed the first Economic Partnership Agreement (EPA) with Japan. Lawmakers have made amendments to several laws which was necessary for the implementation of the agreement, including law on VAT and law on custom. As a result of EPA (included free trade agreements), bilateral trade, trade turnover or the flow of services and products and investment of two countries are considered to be increased. Currently, an annual trade turnover between the two countries is ranging between USD 300-500 million.

Moreover, our businessmen are enabled to introduce Japanese know-how and to boost the export. Following let’s see about some challenges occurred during this period...

## Оршил

Монгол, Япон улсын хооронд дипломат харилцаа тогтоогоод 45 жил өнгөрчээ. Энэ харилцаа нь нийгэм, соёл, эдийн засгийн бүхий л салбарыг хамарч эдүгээ Япон улс нь Монгол Улсын хамгийн том хандивлагч, найдвартай түнш улс болоод байна.

Олон улсад эдийн засгийн хөгжил болон техник, технологийн дэвшлээр тэргүүн эгнээнд багтдаг, 127 сая хүн амтай Япон улс зах зээлээ нээж эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр байгуулсан явдал Монгол Улсын хувьд улс төр, эдийн засгийн томоохон дэмжлэг болсон бөгөөд олон улсын хамтын нийгэмлэг, ялангуяа санхүүгийн зах зээл, гадаадын хөрөнгө оруулагчдад эерэг дохио өгч буй том боломж болов.

Монгол-Японы эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр хэрэгжиж эхлээд жил гаруй хугацаа өнгөрч байна. Харьцангуй богино хугацаанд тус хөтөлбөрийн үр дүн, ач холбогдол, нөлөөг хэлэх боломжгүй хэдий ч цөөн зарим тоо баримтад суурилан энэхүү хэлэлцээрийг илүү өгөөжтэй болгоход юуг анхаарах шаардлагатайг гаргаж тавихыг зорилоо. Өнгөрсөн жил гаруйн хугацаанд хоёр орны хоорондох худалдаа төдийлөн их нэмэгдээгүй явдал

эдийн засгийн түншлэлийг улам идэвхжүүлэхийн тулд зорилтот төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх хэрэгтэйг харуулж байна.

**Монгол Улс-Япон улсын хоорондох гадаад худалдаа**

Монгол Улс 2016 онд дэлхийн 152 улстай худалдаа хийснээс 74 улсад бараа бүтээгдэхүүн экспортолж, 152 улсаас импортоор өөрийн хэрэглээгээ хангаж байна[135]. Үүнээс Япон улстай хийсэн худалдаа олон улстай хийсэн нийт гадаад худалдааны 4 орчим хувь байдаг. Нөгөө талаас Япон улсын нийт гадаад худалдаанд Монгол Улс дөнгөж 0.002 хувийг эзэлдэг нь түнш орны хувьд тус эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр (ЭЗТХ) “худалдааны бус” агуулгатай болох нь харагдаж байна.

Япон улс эдүгээ 14 улстай ЭЗТХ байгуулжээ. Ийнхүү хэлэлцээр байгуулснаар эдгээр орон Японоос оруулсан хөрөнгө оруулалт, худалдаа ихээхэн өссөн байдаг. Тухайлбал, Япон улс 2005 онд Мексик улстай ЭЗТХ байгуулсан бөгөөд тус хэлэлцээрээс хойш Мексикээс Япон руу экспортолсон барааны хэмжээ 22.3, Японоос Мексик руу экспортолсон барааны хэмжээ 44.9 хувиар тус тус өсч, шууд хөрөнгө оруулалт 3 дахин нэмэгдсэн аж. Зүүн өмнөд азийн зарим орны Япон улстай ЭЗТХ байгуулсны дараа гарсан үзүүлэлтийг хүснэгтээр харуулбал дараах эерэг өөрчлөлтүүд ажиглагдаж байна.

**Хүснэгт 1. Япон улстай эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр байгуулсан улс орнууд дахь эдийн засгийн нөлөөлөл**

| | | |
|---|---|---|
| **Сингапур** | 62 | 12 |
| **Тайланд** | 48 | 35 |
| **Индонези** | 38 | 32 |

*Эх сурвалж: Гадаад хэргийн яамны гаргасан судалгаа 2015 он*

Улс орон бүр өөрийн онцлогтой боловч хамтран ашигтай ажиллах нэг хэлбэр нь яах аргагүй эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр байдаг. Иймучраас хоёр улсын хооронд эдийн засгийн түншлэлийн хэлэлцээрийг байгуулснаар хоёр улсын хоорондох худалдаанд эерэг хандлага авчрах хүлээлт хэвээр байна.

[135] Гаалийн 2016 оны 12 сарын статистик мэдээ

Монгол Улсаас Япон улс руу гаргаж буй бүтээгдэхүүнийг авч үзвэл 1.5 сая ам.долларын малын мах болон дайвар бүтээгдэхүүн, 1.5 сая ам.долларын нарийн ширхэгт үс, ноосон ээрмэл утас, 1.5 сая ам.долларын свитер, пуловер, джемпер, жилет болон бусад сүлжмэл гадуур цамц, 1.2 сая ам.долларын ямааны ноолууран сүлжмэл свитер, джемпер, 70 мянган ам.долларын тэмээний угаасан болон самнасан ноос, 613.3 мянган ам.долларын ямааны самнасан ноолуур зэрэг 10 хүрэхгүй цөөн төрлийн бүтээгдэхүүн экспортод гарчээ. Үүнээс ноолууран сүлжмэл, оёмол бүтээгдэхүүнийг эс тооцвол бусад нь дан түүхий эд байна.

**Зураг 1. Монгол Улсаас Япон улс руу экспортолсон бараа бүтээгдэхүүн (сая ам.доллар)**




*Эх сурвалж: Гаалийн Ерөнхий газрын сатистик 2016*

Үүнээс үзэхэд Монгол Улс Япон улсад санал болгох өрсөлдөхүйц (ямааны ноолууран сүлжмэл, оёмол бүтээгдэхүүнээс өөр) бүтээгдэхүүн байхгүй, зөвхөн түүхий эдийн бэлтгэн нийлүүлэгч улс хэвээр байсаар байна.

**Зураг 2. Япон улсаас Монгол Улсад импортолсон бараа, бүтээгдэхүүн (сая ам.доллар)**




*Эх сурвалж: Гаалийн Ерөнхий газрын статистик 2016*

2016 оны байдлаар Япон улсаас импортоор нийт 330.6 сая ам.долларын бүтээгдэхүүн авсан нь манай улсын нийт импортын 9.8 хувийг эзэлж өмнөх оноос 20.4 хувиар өсчээ. Япон улсаас гол төлөв автомашин болон түүний сэлбэг хэрэгсэл, нефтийн бүтээгдэхүүн импортоор орж иржээ. Үүнд 926.4 мянган ам.долларын нефтийн бүтээгдэхүүн, 1.5 сая ам.доллар шинэ дугуй, бульдозер, авто хусуур, 14.7 сая ам.долларын хүнд машин механизм, 185 сая ам.долларын суудлын автомашин байна.

**Зураг 3. Япон улсаас импортоор орж ирсэн бүтээгдэхүүн 2016 он**




*Эх сурвалж: Гаалийн Ерөнхий газрын статистик 2016*

**Хоёр орны худалдаанд тулгамдаж буй асуудал**

Монгол, Япон улсын хоорондох гадаад худалдааны тэнцэл 2016 онд 316.6 сая ам.долларын алдагдалтай гарсан. Япон улсаас импортоор орж ирж байгаа бараа бүтээгдэхүүний хамгийн их хувийг суудлын хуучин автомашин эзэлж байна. Үүнээс үзэхэд Япон улсаас Монгол Улсад хуучин муу машин болон түүний сэлбэг хэрэгслээс өөр бодитой шинэ техник, технологи импортоор орж ирэхгүй байна.

Үүнд дараах хэдэн шалтгаан нөлөөлж байна:

Нэгдүгээрт, Япон улсад бид зөвхөн түүхий эд нийлүүлж байна. Монгол Улсын техник технологийн хоцрогдсон байдал нь өндөр хөгжилтэй оронд өрсөлдөхүйц бүтээгдэхүүнийг санал болгож чадахгүй байна.

Хоёрдугаарт, боловсруулах аж үйлдвэрийн бүтээгдэхүүний экспортыг авч үзвэл 97 хувийг технологийн багтаамжгүй болон нам технологитой бүтээгдэхүүн эзэлж байна.[136] Энэ нь дан ашигт малтмалын бүтээгдэхүүнээ түүхийгээр гаргаж байгаатай холбоотой юм.

Гуравдугаарт, Монгол Улсын үйлдвэрлэлийн өнөөгийн стандарт, технологийн нэвтрэлт муу байгаатай холбоотойгоор дотоодод үйлдвэрлэгдсэн бүтээгдэхүүн экспортод гарч чаддаггүй. Манай улсад аж үйлдвэрлэл хөгжихгүйгээр экспортод эзлэх технологийн багтаамжгүй, нам технологитой бүтээгдэхүүний хувь буурахгүй хэвээр байна.[137]

Ийм учраас хоёр улсын хоорондох эдийн засгийн түншлэлийн хэлэлцээрийн хүрээнд нэн тэргүүнд дараах чиглэлийг анхаарах хэрэгтэй байна. Үүнд:

Монгол Улс малын гаралтай түүхий эдээ боловсруулаагүй, хагас боловсруулсан байдлаар гадагш экспортолсноор өндөр технологид суурилсан энэ төрлийн үйлдвэрлэлийг системтэй хөгжүүлж чадсангүй.

Иймд нэгэнт өгөгдсөн нөөцдөө тулгуурлан мэдлэг, ур чадвар, технологи шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэж өндөр ашиг олох боломжийг бүрдүүлэх нь чухал байна.

[136] Үндэсний хөгжлийн хүрээлэн, “Монгол Улсын хөгжлийн урт хугацааны бодолго 2015-2040” худ. 105.
[137] Эх сурвалж: http://www.trends.nm/ii/2984. Алдах эрхгүй үйлдвэржилт Б.Дөлгөөн Эдийн засагч.

**Зураг 4. Монгол Улсын малын гаралтай бүтээгдэхүүний экспортыг зарим улстай харьцуулсан байдал.**




*Эх сурвалж: Монгол Улсын хөгжлийн урт хугацааны бодлого 2015-2040*

Тухайлбал Монгол Улс малын (адуу, үхэр, хонь, ямаа, гахай) тоогоор Ирланд улсаас 3.3, Финлянд улсаас 18.5, Чех улсаас 14, Норвеги улсаас 23.2 дахин их. Өөрөөр хэлбэл, мал аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэх асар их нөөцтэй боловч зөвхөн арьс, арьсан бүтээгдэхүүний экспортын хэмжээгээр Чех улсаас 37[138], Финлянд улсаас 1.55, Ирланд улсаас 1.07 дахин бага байна.

Монгол Улс Япон улсаас өндөр технологийг нэвтрүүлээд зөвхөн арьс, арьсан бүтээгдэхүүнийг Чех улсын хэмжээнд хүргэж чадвал үүнээсээ 17.7 тэрбум ам.долларын экспортын орлого олох боломжтой[139] гэж судлаачид тооцсоноос үзэхэд манай улсад ихээхэн боломж байгааг илтгэж байна. Цаашлаад уургийн бүтээгдэхүүнийг өндөр технологийн аргаар боловсруулбал энэ үзүүлэлт хэд дахин өсөх боломжтой.

Мөн Япон улс дэлхийн нүүрс, төмрийн хүдрийн томоохон импортлогч орон бөгөөд жилдээ 17.3 тэрбум ам.долларын төрөл бүрийн хүдэр мөн 110.7 тэрбум ам.долларын газрын тос уул уурхайн бүтээгдэхүүний худалдан авалт хийдэг[140]. Эдгээрийн гол нийлүүлэгчид нь эдүгээ ОХУ, Австрали, БНХАУ, Арабын орнууд ажээ. Япон улсын энэ том зах зээлд хамрагдахад манай орны далайд гарцгүй байдал хамгийн том саад бэрхшээлийг учруулж байна. Иймд

[138] Чех улс нь суудлын авто машины сандлын бүрээс, жолооны хүрдний гадаргуу үйлдвэрлэдэг Европын гол үйлдвэрлэгч орон юм. Түүнчлэн гутал, савхин эдлэлийн томоохон үйлдвэрүүдтэй.

[39] Үндэсний хөгжлийн хүрээлэн "Монгол Улсын хөгжлийн урт хугацааны бодлого 2015-2040", худ.111.

[140] www.worldsrichestcountries6com/top Japan_imports.html

манай орон дэд бүтцээ хөгжүүлж, далайн боомт хүртэлх тээврийн өөрийн өртгийг багасгах бүхий л арга замыг эрэлхийлж, төрөл бүрийн худалдааг хөнгөвчлөх хөтөлбөр болон олон улсын далайд гарцгүй орнуудын хамтын ажиллагаанд идэвхтэй оролцож ажиллах нь чухал байна.

Уул уурхайн бүтээгдэхүүний өртгийг нэмэгдүүлэхийн тулд Япон улсын хөрөнгө оруулалтыг татаж чадвал манай орны харьцангуй хямд ажиллах хүчний нөөцөөр дэлхийн хэмжээний чанар, стандартын бүтээгдэхүүн үйлдвэрлэх боломж бүрдэнэ.

Япон улсаас Монгол Улсад хийсэн хөрөнгө оруулалт, зээл тусламж

Юуны түрүүнд, Монгол Улс болон Япон улсын хооронд хийгдсэн харилцан ашигтай төслийг дурдъя. Энэ бол бидний сайн мэдэх Япон улсын тусламжаар 1981 онд байгуулагдсан, эдүгээ дэлхийн хэмжээний ноос, ноолууран бүтээгдэхүүн үйлдвэрлэгч "Говь" ХК билээ. Мөн харилцаа холбоо, дэд бүтэц зэрэг олон салбарт өөрийн зээл, тусламжаа үзүүлж байна.

Япон улсаас Монгол Улсад олгосон зээл, тусламж. Монгол Улсын хамгийн том хандивлагч орон нь Япон бөгөөд өнгөрсөн хугацаанд манай орны дэд бүтэц, үүнээс цахилгаан станцыг түлшээр хангах болон нүүрсний уурхайн үйл ажиллагаанд зориулж уул уурхайн техник, тоног төхөөрөмж нийлүүлж байсан билээ. Эдгээр тоног төхөөрөмжийн хэвийн үйл ажиллагаа, засвар үйлчилгээг хангах зорилгоор Японы хөрөнгө оруулалттай КОМИТ компанийг байгуулсан нь албан ёсны зээл тусламжийг дагаж гадаадын шууд хөрөнгө оруулалт орж байгаагийн нэг жишээ билээ.

Япон улсын зээл тусламжийг үндсэн 4 гол салбарт хувааж болно:

1. Эдийн засгийн хөгжлийн үндсэн суурь болох дэд бүтцийн салбар.
2. Хүний хөгжлийн хөтөлбөр.
3. Хөдөө аж ахуй, мал аж ахуйн салбар.
4. Нийгмийн хөгжлийн хүрээний тусламж. Үүнд: Боловсрол, эрүүл мэнд, даатгалын зэрэг салбар юм.

Япон улсын Засгийн газраас олгож буй зээл тусламж манай орны бүхий л салбарыг хамарч Монгол Улсын хөгжилд ихээхэн хувь нэмэр оруулж байна. Өнөөдөр Япон улсын тусламж хүртээгүй салбар, аймаг, сум бараг үгүй билээ.[141]

[141] Түүнчлэн манай улсад тохиолдсон цаг үеийн хүндрэл болох гол түймэр, ган зудыг даван туулахад ихээхэн хэмжээний буцалтгүй тусламж үзүүлж байсан болно. Мөн Улаанбаатар

Япон улсаас Монгол Улсад зээл, тусламж ихээр үзүүлж байгаа боловч тодорхой нэг салбарын чиглэлд "Говь” ХК-аас хойш томоохон гэх үйлдвэр баригдсангүй. Ийм учраас Монгол Улсын эдийн засагт нөлөөлөх хэмжээний томоохон үйлдвэрийн төслийг хамттай хэрэгжүүлэх бодлого баримтлах нь чухал болоод байна.

Монгол, Япон улсын хоорондох эдийн засгийн түншлэлийн хэлэлцээрийн үр өгөөжийг нэмэгдүүлэх боломж

Японд аж үйлдвэрийн болон мэдлэгт суурилсан кластеруудыг[142] амжилттай хөгжүүлж байна. Япон улсын бүх бүс нутгийг хамарсан кластеруудын сүлжээ бий болсон бөгөөд кластерууд нь энэ улсад эдийн засгийн өрсөлдөх чадварыг болон бизнесийн орчинг сайжруулах хамгийн оновчтой арга хэрэгсэлд тооцдог. Дэлхийн олон орны судлаачид өнөөдөр Японы туршлагыг ихээхэн сонирхож байгаа юм. Хоккайдо арал дээр 1990-ээд оны эхний хагаст анх аж үйлдвэрийн кластерийн тогтвортой хөгжлийг хангах, дэмжих төвийг байгуулан ажиллуулсан ба Япон улсын Засгийн газраас 2001-2005 онд аж үйлдвэрийн болон мэдлэгт суурилсан кластеруудыг байгуулах ажлыг орон даяар эрч далайцтай өрнүүлсэн[143]. Японы кластерууд 2006-2010 онд эрчимтэй хөгжсөн бөгөөд 2011 оноос улс орны эдийн засгийн өсөлтөд ихээхэн чухал үүрэг гүйцэтгэх боломжтой болсон гэж судлаачид үзэж байна. Японы кластерууд анх туслан гүйцэтгэх гэрээ (Subcontract)-нд

хотын гал түймэртэй тэмцэх техник хэрэгслийг сайжруулахад зориулсан буцалтгүй тусламж, Соёлын өвийн төвийн шинжилгээний тоног төхөөрөмжийг сайжруулахад зориулсан соёлын буцалтгүй тусламж зэрэг техник, тоног төхөөрөмжийн тусламжийг байнгын үзүүлж байдаг.

Япон улсын тусламжтайгаар манай урд хил дээр бараа шилжүүлэн ачих байгууламж барьсан явдал нь манай улсын ачаа тээвэрлэлтийн хүчин чадлыг сайжруулаад зогсохгүй Монголоор дамжуулан бараагаа тээвэрлэдэг Хятад, Орос, Зүүн Европын орнуудад ч ихээхэн тустай болж олон улсын худалдааг хөгжүүлэхэд зохих дэмжлэг болсон байна.

Мөн төвийн эрчим хүчний шугамаас алслагдсан 171 сумдын дизель станцыг шинэчлэсэн, Улаанбаатар хотын IV цахилгаан станцыг шинэчлэн сайжруулсан нь хот, хөдөөгийн хөдөлмөрчдийг цахилгаан эрчим хүчээр тасралтгүй хангах, өвлийг тав тухтай давахад үнэлж баршгүй ач тус болсон билээ.

Үүнээс гадна Японы тусламжаар Улсын нэгдсэн II эмнэлэг, Хавдар судлалын төв, Эх нялхсын төв зэрэгт шаардлагатай зарим эмнэлгийн тоног төхөөрөмж нийлүүлсэн бөгөөд энэ нь манай хот хөдөөгийн хүн амын эрүүл мэндийг хамгаалах үйлсэд маш их хувь нэмэр болсон билээ.

[142] Системийн хандлагын үүднээс авч үзвэл кластер нь нэгдсэн зохион байгуулалтад орсон бөгөөд тодорхой зорилготой үйл ажиллагаа явуулж байдаг харилцан хамааралтай янз бүрийн салбарын субъектүүдын цогц нэгдэл юм. “Монгол Улсад үндэний өрсөлдөх чадварыг дээшлүүлэх зорилгоор махны, ноос, ноолуурын, чацарганы үйлдвэрлэлийн болон аялал жуулчлалын кластерийг хөгжүүлэх нөхцөл байдлын үнэлгээ” номноос, Улаанбаатар хот, 2013 он

[143] Industrial Cluster Project. Ministry of Economy, Trade and Industry of Japan. 2008

тулгуурлан үйл ажиллагаагаа явуулж эхэлжээ. Ийм гэрээг том компаниуд жижиг, дунд үйлдвэрлэлийн компаниудтай байгуулан ажиллах явдал түгээмэл болжээ. Жишээлбэл, автомашин үйлдвэрлэлийн Тоёото (Toyota) компани 122 шууд нийлүүлэгч, 36 мянган туслан гүйцэтгэх гэрээтэй жижиг, дунд үйлдвэрлэлийн компаниудтай хамтран ажилладаг байна. Сүүлийн жилүүдэд Япон улсын Засгийн газар кластеруудыг байгуулан хөгжүүлэх чиглэлээр бүр ч их анхаарч байгаа юм. Зөвхөн 2006-2010 онд орон даяар Засгийн газрын санхүүжилттэй аж үйлдвэрийн кластерийн 18, мэдлэгт суурилсан кластерийн санаачлагын 13 томоохон төслийг хэрэгжүүлсэн байна[144].

Иймээс Япон улсын туршлагыг нэвтрүүлж Монгол Улсад ноос, ноолуурын, махны, чацарганы кластерүүдийг хөгжүүлэх боломжтой юм. Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээрийн үр өгөөжийг нэмэгдүүлэхэд дан ганц компаниуд, хувь хүмүүсийн хоорондох харилцаанаас гадна кластерүүдийг хөгжүүлэхэд хамтарч ажиллах бүрэн боломжтой.

## Дүгнэлт, санал

Олон улсад эдийн засгийн хөгжлөөр тэргүүлэгч улсын нэг болох Япон улстай ЭЗТХ байгуулсан нь Монгол Улсын хөгжилд томоохон дэмжлэг болохоос гадна олон улсын хамтын нийгэмлэг, ялангуяа санхүүгийн зах зээл, гадаадын хөрөнгө оруулагчдад эерэг дохио өгч буй том боломж юм.

Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр байгуулаад дөнгөж нэг жил өнгөрч байгаа хэдий ч уг хэлэлцээрийн үр ашгийн нэмэгдүүлэхэд анхаарах цөөнгүй асуудлууд байна.

Тухайлбал ЭЗТХ бодит үр өгөөжийг бүрэн хэмжээгээр ашиглахын тулд Япон улсын хөрөнгө оруулалт, худалдааг эрчимтэй нэмэгдүүлэх тал дээр онцгой анхаарч энэ чиглэлийн хууль, эрх зүйн орчныг улам боловсронгүй болгож, саад тотгор болж байгаа заалтуудыг уялдуулах ажлыг гүйцэтгэх нь зүйтэй юм.

Япон улс Монгол Улсаас уул уурхайн эрдэст бүтээгдэхүүнийг авах сонирхол их тул уг салбарт эцсийн боловсруулалт хийгдэх үйлдвэрүүдэд Япон улсын өндөр технологийг татах хэрэгтэй. Энэ тал дээр хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх хэрэгцээ байна.

Энэхүү ЭЗТХ-ийн үр өгөөжийг бодитоор нэмэгдүүлэхэд хамгийн их асуудал дагуулж буй асуудал бол тэвэр ложистикийн өртөг юм. Үүнийг

[144] Takao Shimizu. Forging International Tie-Ups between Industrial Clusters, 2008

бууруулахад Монгол Улсын “Талын зам”. БНХАУ-ын “Бүс ба зам”, ОХУ-ын “Транс Евразийн" санаачилгын хүрээнд тус тус бүтээн байгуулах тээврийн коридортой уялдуулах замаар шийдвэрлэх боломжтой.

Япон улсын өндөр шаардлагатай зах зээлд гарахын тулд өөрийн орны стандарт хэмжүүрийг өсгөх шаардлага байна. Үний тулд өөрийн нөөц бололцоог бүрэн дайчилж олдож байгаа боломжуудыг бүрэн ашиглаж хувь хүн. компаниудын хоорондох харилцаа бэхжүүлэх нь чухал юм.

Хувь хүн, компаниас гадна Монгол Улсын төрийн зүгээс улс орны хөгжлийн тэргүүн зэргийн хөтөлбөр, төслүүдэд тулгуурлан тодорхой төсөл хөтөлбөрийг боловсруулж эрдэмтэн мэргэдээр хэлэлцүүлж, улмаар тусгай хөтөлбөр гаргаж ажиллах нь манай орны хувьд тулгамдсан сорилт болоод байна.

## Эх сурвалжийн жагсаалт


1. Agreement between Mongolia and Japan for an economic partnership,
2. Гаалийн 2016 оны 12 сарын статистик мэдээ
3. Үндэсний хөгжлийн хүрээлэн “Монгол Улсын хөгжлийн урт хугацааны бодлого 2015-2040”
4. Takao Shimizu. Forging International Tie-Ups between Industrial Clusters, 2008
5. Industrial Cluster Project. Ministry of Economy, Trade and Industry of Japan. 2008
6. www.worldsrichestcountries6com/topjapan_imports.html
7. Алдах эрхгүй үйлдвэржилт Б.Дөлгөөн Эдийн засагч. http://www.trends.mn/n/2984.